



МОНГОЛ УЛСЫН
ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН
ГИШҮҮНИЙ ТОГТООЛ

Улаанбаатар хот

2021 оны 02 сарын 02 өдөр

Дугаар 13

Маргаан нэгтгэн шалгах тухай

Нэг. Иргэн Т.Доржханд, Д.Үүрцайх нарын мэдээллийн дагуу Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Гучдугаар зүйлийн 2 дахь хэсгийг; мөн хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэж заасныг зөрчсөн эсэх асуудлаар мэдээлэл ирүүлснийг Үндсэн хуулийн цэцийн гишүүн 2021 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэн шалгаж байгаа болно.

Хоёр. Иргэн Г.Батаа Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хандаж Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4, 5.6 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Гучдугаар зүйлийн 2 дахь хэсгийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх асуудлаар мэдээлэл ирүүлснийг Үндсэн хуулийн цэцийн гишүүн 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 12 дугаар тогтоолоор мөн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэн шалгаж байна.


ҮНДЭСЛЭЛ:

Үндсэн хуулийн цэцийн гишүүний 2021 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 11, 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 12 дугаар тогтоолоор тус тус маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэн шалгаж байгаа маргааны агуулга нь адил буюу нэг асуудал байх тул Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8 дахь заалтын дагуу нэгтгэн шалган шийдвэрлэх үндэслэлтэй байна.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8 дахь заалтыг удирдлага болгон **ТОГТООХ НЬ:**

1. Иргэн Г.Батаагийн мэдээллийн дагуу үүсгэсэн маргааныг Үндсэн хуулийн цэцийн гишүүний 2021 оны 11 дүгээр тогтоолоор үүсгэсэн маргаантай нэгтгэн шалгасугай.

ГИШҮҮН



Д.СОЛОНГО